


Банкны салбарын шинэчлэлтэй холбоотойгоор системийн нөлөө бүхий банкууд хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд хувьцаагаа арилжаалж эхлээд байгаа билээ. Үүнтэй холбоотойгоор бидний зүгээс банкны салбарын гол үзүүлэлтүүдийн талаар 7 хоног бүр нэгтгэн харилцагч, хөрөнгө оруулагч нартаа хүргэж буй. Энэ 7 хоногт бид банкны АКТИВ-ын талаар мэдээлэл бэлтгэлээ.

## **БАНКУУДЫН НИЙТ АКТИВ**

2022 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын нийт активын хэмжээ 46.0 их наяд төгрөг байв.

Үүнээс 18.1% буюу 8.3 их наяд төгрөг нь Банкны нөөц хэлбэрээр, 12.3% буюу 5.6 их наяд төгрөг нь Төв банкны үнэт цаас хэлбэрээр, 7.5% буюу 3.4 их наяд төгрөг нь Гадаад актив хэлбэрээр, 3.6% буюу 1.7 их наяд төгрөг нь Засгийн газрын авлага хэлбэрээр, 44.1% буюу 20.3 их наяд төгрөг нь бусдад олгосон зээл хэлбэрээр, 4.1% буюу 1.9 их наяд төгрөг нь Үндсэн хөрөнгө хэлбэрээр, 10.2% буюу 4.7 их наяд төгрөг нь бусад актив хэлбэрээр илэрхийлэгдсэн байна.

Нийт банкуудын актив, их наяд төгрөг



Сүүлийн 5 жилийн хугацаанд банкуудын нийт активын хэмжээ нэрлэсэн дүнгээр 17.2 их наяд төгрөгөөр буюу 59.7%-иар өсчээ. Мөн хугацаанд жилийн дундаж өсөлт (CAGR) нь 9.8%-тай байжээ.

Банкны актив буюу хөрөнгө гэдэг нь банкны хяналтад байгаа бөгөөд өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсч, ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөх нөөц юм.

Активыг дараах 11 дэд бүлэгт ангилна:

1. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө
2. Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө
3. Хөрөнгө оруулалт
4. Зээл
5. Дериватив санхүүгийн хөрөнгө
6. Бусад санхүүгийн хөрөнгө
7. Бусад санхүүгийн бус хөрөнгө
8. Үндсэн хөрөнгө
9. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө
10. Борлуулах зориулалттай хөрөнгө
11. Биет бус хөрөнгө

Эх сурвалж: Банкны Нягтлан Бодох Бүртгэлийн Заавар


Ковид-19 цар тахлын жилүүдэд банкуудын нийт активын өсөлт харьцангуй бага байсан нь урт хугацааны хөл хорионоос үүдэн эдийн засгийн бүхий л салбарууд зогсонги байдалд байсантай холбоотойгоор тайлбарлагдах болов уу. Харин 2021 оноос хорио цээрийн дэглэм суларч, бизнесүүд эргэлтэд орж эхэлсэнээр банкуудын нийт активын хэмжээ хурдацтай нэмэгдэж 2022 оны жилийн эцэс гэхэд 46.0 их наяд төгрөгт хүрсэн байна.

Түүнчлэн нийт активт эзлэх зээлийн хэмжээ 2021 онд 47.0% байсани бол 2022 онд 44.1% хүртлээ буурсан байна. Эсрэгээрээ нийт активт эзлэх нөөцийн хэмжээ 2021 онд 10.9% байсан бол 2022 онд 18.1% болж өссөн байна. Энэ нь системийн нөлөө бүхий банкууд нээлттэй компани болохтой холбоотойгоор зээл олголтоо бууруулсан байх магадлалтай.

# БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ-4

## Системийн нөлөө бүхий банкуудын НИЙТ АКТИВ

Системийн нөлөө бүхий банкуудын нийт актив, их наяд төгрөг



банкуудын активын хэмжээ тасралтгүй өсч 28.5 их наяд төгрөгөөс 46.0%-иар өсч 41.6 их наяд төгрөгт хүрсэн байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар банкуудын нийт активын 41.6 их наяд төгрөг буюу 90.6%-ийг системийн нөлөө бүхий том 5 банкуудын актив бүрдүүлж байна.

Үүнээс активын хэмжээгээрээ хамгийн том нь 15.1 их наяд төгрөгийн активтай Хаан банк байна.

Сүүлийн 5 жилийн хугацаанд системийн нөлөө бүхий